



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/650

Алтай хот

Газрын талбайн хэмжээ өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Алтай хотын Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө (2015-2030 он)”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Алтай хотын инженерийн байгууламж бүхий бүсэд эзэмшил газрын талбайн хэмжээ өөрчлөх хүсэлт ирүүлсэн Говь-Алтай аймаг дахь Монгол банкны салбарын эзэмшиж байгаа газрын хэмжээг өөрчлөн хавсралтаар баталж эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшсэн Говь-Алтай аймаг дахь Монгол банкны салбарын мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэн баталгаажуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

3.Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/495 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА




О.АМГАЛАНБААТАР


**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ МОНГОЛ БАНКНЫ САЛБАР (2491532) - ИЙН
ЭЗЭМШИХ ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ**

Нэгж талбарын дугаар: 820800.....

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Оргил баг



Огноо: 2022-08-09



Хашааны координат:

Дугаар	X	Y	Урт	Цөлмд
1	5139300.058	289138.709	1.33	1-2
2	5139300.423	289139.992	1.10	2-3
3	5139301.458	289139.631	5.78	3-4
4	5139306.918	289137.730	4.03	4-5
5	5139308.201	289141.547	4.01	5-6
6	5139312.000	289140.270	5.15	6-7
7	5139316.940	289138.800	2.76	7-8
8	5139319.584	289138.000	35.84	8-9
9	5139329.962	289172.309	29.36	9-10
10	5139302.058	289181.429	41.32	10-11
11	5139288.444	289142.419	12.19	11-1

Талбайн хэмжээ: 1174.6 квадрат метр

Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)